



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/607

Номгон

「Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх "Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 8/10 дугаар тогтоол, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх "Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс удирдамжийн дагуу зохион байгуулсугай.


2.Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх "Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээ зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Арга хэмжээг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар /Ж.Алтанцэцэг/ -т үүрэг болгосугай.

3.Арга хэмжээний зардал болох 2.700.000 (Хоёр сая долоон зуун мянган төгрөг)-ийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний "Бага насны хүүхдийн цогц хөгжил" стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (В.Наранчимэг)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311601

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 15 ны өдрийн 1627 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

## УДИРДАМЖ

Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх  
"Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээ  
зохион байгуулах тухай

**Зорилго** Эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоотойгоор хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, ахуйн хүрээний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хүүхдийг ахуйн осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчны эрсдэлийг үнэлж, шаардлагатай арга хэмжээг авах ажлыг зохион байгуулах.

### **Зорилт:**

Эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, аж ахуй нэгж байгууллагуудад "ХАМТДАА ШАЛГАЯ, ХАМГААЛЪЯ" арга хэмжээг сурталчлан таниулах ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.

Иргэд, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчдаар дамжуулан гэр орчны аюулгүй байдлын үнэлгээг хийж, эрсдэлийг бууруулах аргачлал, зөвлөмж хүргэх.

Аж ахуй нэгж, байгууллагаар дамжуулан байгууллагын гадна, дотно орчны үнэлгээ хийж эрсдэлийг бууруулах ажлыг зохион байгуулах.

Сэргийлж болох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх.

### **Хугацаа:**

2023 оны 11 дүгээр 15-ны өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийг дуустал

### **Ерөнхий зохион байгуулагч:**

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

Боловсрол, шинжлэх ухааны газар

### **Хамрах хүрээ:**

Орон нутгийн айл, өрх, иргэд, олон нийт

Орон нутгийн төр, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж

### **Арга хэмжээний чиглэл:**

1. Эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, аж ахуй нэгж байгууллагуудад "Хамтдаа шалгая, хамгаалъя" арга хэмжээг сурталчлан таниулах.

## 2.

2.Гэр, орчны аюулгүй байдлыг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах талаар зөвлөмж мэдээлэл хүргэх.

3.Гэрээс сургууль хүрэх орчны аюулгүй байдлыг үнэлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

4.Төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн байгууллагад хамаарах гадаад болон дотоод орчинд хүүхдийн аюулгүй байдал талаас үнэлж эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах.

5.“Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээг зохион байгуулсан ажлын тайланг хүргүүлэх.

6.Хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг илрүүлэх, хоол тэжээлийн байдлыг сайжруулахад анхаарч эцэг эхийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.

### **Хүрэх үр дүн:**

“Хамтдаа шалгая, хамгаалъя” арга хэмжээг зохион байгуулснаар эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, аж ахуй нэгж байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, орчны эрсдэлийг бууруулж, хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангасан байна.

Аймгийн Засаг даргын ~~2013~~ оны 11 дүгээр сарын 15 ны өдрийн 4/607 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХҮҮХДИЙГ ОРЧНЫ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН  
СЭРГИЙЛЭХ "ХАМТДАА ШАЛГАЯ, ХАМГААЛЪЯ"  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Хийгдэх ажил	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шатахууны зардал Баянхонгор-Бөмбөгөр Бөмбөгөр-Бууцагаан Бууцагаан-Баянхонгор Баянхонгор сумын 16 цэцэрлэг	20 л Нийт 460 км	2530*92 л	232.760
2	Ажиллах мэргэжилтнүүдийн томилолт (Бөмбөгөр, Бууцагаан сум)	4 хүн	24.000*2 хоног	192.000
3	Эцэг эхчүүдэд тараах гарын авлага	710	710*500	355.000
4	Эцэг эхчүүдэд зориулсан зөвлөлдөх уулзалт, сургалт	Үдийн цай, хоол	90*12.000	1.080.000
5		Бал	90*500	45.000
6		Дэвтэр	90*4500	405.000
7		Уут	90*450	40.500
8		Бичгийн цаас	2*20000	40.000
9	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах сургалтын зардал	11 хүн	11*28158	309740
	<b>Нийт</b>			<b>2.700.000</b>

оОо

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 13 ны өдрийн 1605 дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

“МАЛ, МАХ-2023” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД АЖИЛЛАХ  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХУВААРЬ

д/д	Хариуцах албан байгууллага	Тээврийн хэрэгслийн марк дугаар	Гарч ажиллах өдөр	Үүрэг гүйцэтгэх авто машин өөрчлөгдсөн эсэх
1.	Баянхонгор сумын ЗДТГазар		XI/15	
2.	Мал эмнэлгийн газар		XI/16	
3.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар		XI/17	
4.	Цагдаагийн газар		XI/18	
5.	Онцгой байдлын газар		XI/19	
6.	Аймгийн Засаг даргын Тамгын газар		XI/20	
7.	Баянхонгор сумын ЗДТГазар		XI/21	
8.	Мал эмнэлгийн газар		XI/22	
9.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар		XI/23	
10.	Цагдаагийн газар		XI/24	
11.	Онцгой байдлын газар		XI/25	
12.	Аймгийн Засаг даргын Тамгын газар		XI/26	
13.	Баянхонгор сумын ЗДТГазар		XI/27	
14.	Мал эмнэлгийн газар		XI/28	
15.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар		XI/29	
16.	Цагдаагийн газар		XI/30	
17.	Онцгой байдлын газар		XII/01	
18.	Аймгийн Засаг даргын Тамгын газар		XII/02	
19.	Баянхонгор сумын ЗДТГазар		XII/03	
20.	Мал эмнэлгийн газар		XII/04	
21.	Байгаль орчин, аялал жуулчлалын газар		XII/05	
22.	Цагдаагийн газар		XII/06	
23.	Онцгой байдлын газар		XII/07	
24.	Аймгийн Засаг даргын Тамгын газар		XII/08	